



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/415

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Сумын төвийн гэрэлтүүлэг (Баян-Агт сум)” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Нарт импекс” ХХК-тай 137,800,000 (нэг зуун гучин долоон сая найман зуун мянган) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Нарт импекс” ХХК-ийн захирал (Ц.Батзул)-д даалгасугай.

3. Хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Баян-Агт сумын Засаг дарга (Б.Бямбажав)-д даалгасугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 12-ний өдрийн
А/415 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Нормчлолын сан	208,003	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	2,311,145	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	1,155,572	Ү.Бямбасүрэн
4	Магадалшгүй ажил	2,311,145	Ү.Бямбасүрэн
5	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 30 хоног	Ү.Бямбасүрэн
6	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	9,900,000	Б.Ариунболд
7	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Ариунболд
8	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн
9	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Б.Ариунболд